



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/46

Дуурсах

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын А/780 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “100 дугуйчин-100 километр” унадаг дугуйн аялалын үйл ажиллагаанд идэвхтэй оролцон аялалын 78 километрт өртөө гарган байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажилласугай.

2. Үйл ажиллагааг зохион байгуулах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Олон нийтийг идэвхтэй хөдөлгөөнд уриалж, дархлаагаа дэмжин дасгал хөдөлгөөнөөр хичээллэх сонирхол, санаачилгыг нэмэгдүүлэх, тэднийг хөдөлгөөний дутагдал, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “100 дугуйчин-100 километр” унадаг дугуйн аялалын үйл ажиллагааг зохион байгуулахыг ахмад настан, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Амарсайнуу)-д үүрэг болгосугай.


4. Үйл ажиллагаанд зарцуулах 803.950 (Найман зуун гурван мянга есөн зуун тавь) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулахыг Ахлан нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  ЭНХЖАРГАЛ



Эрүүл мэндийн газрын даргын оны
..... дугаар сарын ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт



“100 ДУГУЙЧИН-100 КИЛОМЕТР” УНАДАГ ДУГУЙН АЯЛАЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ ₮	Нийт үнэ ₮
1	2	3	4	5	6
1	Цайны зардал	-	-	-	202 750
2	Шатахуун	л	40	2530	101 200
3	Оролцооны зардал	-	-	-	500 000
Нийт зардал					803.950

-----o0o-----